

## **БНХАУ-руу импортлох хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч аж ахуйн нэгжийг бүртгэх захиргааны журам**

**(БНХАУ-ын Гаалийн ерөнхий газрын 248 дугаар тушаалаар баталсан)**

### **БҮЛЭГ 1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

**1 дүгээр зүйл.** БНХАУ-руу импортлох хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч аж ахуйн нэгжийн бүртгэл, хяналтыг сайжруулахын тулд “БНХАУ-ын Хүнсний Аюулгүй Байдлын тухай” хууль түүнийг хэрэгжүүлэх журмууд, “БНХАУ-ын экспорт, импортын барааны хяналт шалгалтын тухай” хууль түүнийг хэрэгжүүлэх журмууд, “БНХАУ-ын амьтан, ургамлын экспорт, импортын хорио цээрийн тухай” хууль түүнийг хэрэгжүүлэх журмууд, “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын хяналтыг сайжруулах тухай” Төрийн Зөвлөлийн тусгай журам зэрэг эрх зүйн баримт бичгийг үндэслэн тус журмыг боловсруулав.

**2 дугаар зүйл.** БНХАУ-руу импортлох хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх, боловсруулах, хадгалах үйл ажиллагаа эрхлэгч гадаад улсын аж ахуйн нэгж /цаашид “Импортын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч гадаадын ААН” гэнэ/-ийг бүртгэх үйл ажиллагааг энэ журмаар зохицуулна.

Дээр дурьдсан импортын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч гадаадын ААН-д хүнсний нэмэлт болон хүнсний бүтээгдэхүүнтэй холбоотой бусад бүтээгдэхүүний үйлдвэрлэл, боловсруулалт, хадгалалтын үйл ажиллагаа эрхэлдэг ААН хамаарахгүй.

**3 дугаар зүйл.** БНХАУ-ын Гаалийн Ерөнхий Газар /цаашид “ГЕГ” гэх/ нь импортын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч гадаадын ААН-ийн бүртгэлийн асуудлыг хариуцна.

**4 дүгээр зүйл.** Импортын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч гадаадын ААН нь ГЕГ-г бүртгүүлсэн байна.

### **БҮЛЭГ 2. БҮРТГЭХ НӨХЦӨЛ, ДАРААЛАЛ**

**5 дугаар зүйл.** Импортын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч гадаадын ААН-ийн бүртгэлийн нөхцөл:

- (1) Тухайн улсын хүнсний аюулгүй байдлын тогтолцоо нь ГЕГ-ын хяналт, үнэлгээний шаардлагыг хангасан байна.
- (2) Тухайн улсын төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр болон үр дүнтэй хяналтын дор үйл ажиллагаа явуулдаг байна.
- (3) Импортын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч гадаадын ААН нь хүнсний аюулгүй байдал, ариун цэврийн үр дүнтэй удирдлагын тогтолцоог нэвтрүүлсэн, хууль ёсны дагуу хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг, экспортлодог, түүнчлэн БНХАУ-д экспортлож буй хүнсний бүтээгдэхүүн нь БНХАУ-ын хүнсний аюулгүй байдлын стандарт, холбогдох хууль, дүрмийн шаардлагыг хангасан байна.
- (4) ГЕГ болон тухайн улсын эрх бүхий байгууллага хооронд байгуулсан хэлэлцээр, хорио цээр, хяналт шалгалтын шаардлагыг хангасан байна.

**6 дугаар зүйл.** Импортын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч гадаадын ААН-ийн бүртгэл нь 1) тухайн улсын эрх бүхий байгууллагын бүртгүүлэх санал 2) ААН-ийн бүртгүүлэх хүсэлтээс бүрдэнэ.

ГЕГ нь хүнсний бүтээгдэхүүний түүхий эдийн гарал үүсэл, үйлдвэрлэх, боловсруулах технологи, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын талаарх өмнөх (түүхэн) мэдээлэл, зорилтот хэрэглэгчид, хоол хүнсэнд хэрэглэх арга зэрэг бусад хүчин зүйлд дүн шинжилгээ хийж, олон улсын дүрэм журамтай уялдуулан бүртгүүлэх хүсэлт гаргаж буй импортын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч гадаадын ААН-ийг бүртгэх арга хэлбэр болон бүрдүүлэх бичиг баримтыг тодорхойлж болно.

Хэрэв эрсдлийн задлан шинжилгээгээр, эсвэл баримтаар тодорхой нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний эрсдэлд өөрчлөлт орсон бол ГЕГ бүртгэх арга, хэлбэр болон бүрдүүлэх материалд зохицуулалт хийж болно.

**7 дугаар зүйл.** Дараах нэр төрлийн импортын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч гадаадын ААН-ийг тухайн улсын эрх бүхий байгууллагаас ГЕГ-т бүртгүүлэхээр санал болгоно.

- мах, махан бүтээгдэхүүн,
- өлөн гэдэс,
- далайн гаралтай хүнсний бүтээгдэхүүн,
- сүү, сүүн бүтээгдэхүүн
- хараацайн үүр болон үүрээр хийсэн бүтээгдэхүүн,
- зөгийн гаралтай бүтээгдэхүүн,
- өндөг болон өндгөөр хийсэн бүтээгдэхүүн,
- хүнсний өөх, тос болон тосны түүхий эд,
- шанзтай гурилан бүтээгдэхүүн,
- хүнсний үр тариа,
- нунтагласан үр тарианы бүтээгдэхүүн, соёолж (malt)
- шинэ болон хатаасан ногоо, шошнууд
- амтлагчууд,
- самар болон үр,
- хатаасан жимс,
- хуураагүй кофены үр болон какаогийн шош,
- тусгай зориулалтын хүнс,
- эрүүл мэндийг дэмжих бүтээгдэхүүн.

**8 дугаар зүйл.** Тухайн улсын эрх бүхий байгууллага бүртгүүлэх санал гаргасан өөрийн улсын ААН-д хяналт шалгалт хийж, бүртгэлийн нөхцөл, шаардлагыг хангасан ААН-ийг ГЕГ-т “Импортын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч гадаадын ААН”-ээр бүртгүүлэх саналыг дараах материалын хамт илгээнэ:

- 1) Тухайн улсын эрх бүхий байгууллагын албан бичиг,
- 2) Бүртгүүлэхээр санал болгож буй ААН-ийн нэрс болон ААН-ийн бүртгүүлэх хүсэлт,
- 3) ААН-ийг тодорхойлох эрх зүйн бичиг баримтууд. Үүнд тухайн улсын эрх бүхий байгууллагаас олгосон бүртгэлийн гэрчилгээ болон зөвшөөрөл,
- 4) Тухайн улсын эрх бүхий байгууллагын санал болгосон ААН нь бүртгэлийн нөхцөл, шаардлагыг хангасан тухай мэдэгдэл,

5) Тухайн улсын эрх бүхий байгууллагаас тухайн ААН-д хийсэн хяналт, шалгалтын тайлан.

Шаардлагатай бол ГЕГ тухайн ААН-ээс үйлдвэрийн байр, хөргүүрийн план зураг, боловсруулах хэсгийн урсгалын зураглал гэх мэт хүнсний аюулгүй байдал, ариун цэвэр, хамгаалалтын тогтолцоотой холбоотой бичиг баримтыг шаардаж болно.

**9 дүгээр зүйл.** Энэ тогтоолын 7 дугаар зүйлд заасан хүнсний бүтээгдэхүүнээс бусад хүнсний бүтээгдэхүүнийг гадаад улсад үйлдвэрлэгч ААН нь өөрөө болон өөрийн итгэмжит төлөөлөгчөөр дамжуулан ГЕГ-т бүртгүүлэхдээ дараах материалыг бүрдүүлнэ:

- 1) ААН-ийн бүртгүүлэх хүсэлт;
- 2) ААН-ийг тодорхойлох эрх зүйн бичиг баримтууд. Үүнд тухайн улсын эрх бүхий байгууллагаас олгосон бүртгэлийн гэрчилгээ болон зөвшөөрөл;
- 3) Энэ зохицуулалтын шаардлагыг байнга дагаж сахин мөрдөхөө амалсан ААН-ийн мэдэгдэл.

**10 дугаар зүйл.** ААН бүртгүүлэх хүсэлтэд дараах мэдээллийг тусгана: ААН-ийн нэр, ААН оршиж байгаа улс, үйлдвэрийн байрлалын хаяг, хууль ёсны төлөөлөгчийн нэр, холбоо барих хаяг, тухайн улсын эрх бүхий байгууллагын бүртгэлийн дугаар, бүртгүүлэх хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл, үйлдвэрлэлийн төрөл, үйлдвэрийн хүчин чадал гэх мэт мэдээлэл байна.

**11 дүгээр зүйл.** ААН-ийн бүртгүүлэх хүсэлтийн бичиг баримтыг хятад эсвэл англи хэлээр бүрдүүлнэ. Тухайн ААН байрлаж байгаа улс БНХАУ-ын ЗГ-тай бүртгүүлэх арга, бүрдүүлэх материалын талаар тусгайлан байгуулсан хэлэлцээртэй бол хоёр тал хэлэлцээрийн шаардлагыг дагаж мөрдөнө.

**12 дугаар зүйл.** Тухайн ААН байрлаж байгаа улсын эрх бүхий байгууллага болон импортын хүнсний бүтээгдхүүн үйлдвэрлэгч гадаадын ААН бүрдүүлсэн материалынхаа үнэн зөв, бүрэн бүтэн байх, хууль ёсны байх хариуцлагыг бүрэн хүлээнэ.

**13 дугаар зүйл.** ГЕГ дангаараа буюу итгэмжит байгууллагаар дамжуулан үнэлгээний баг бүрдүүлж, баримт бичгийн шалгалт, цахимаар, газар дээр нь шалгах зэрэг арга, хэлбэрээр импортын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч гадаадын ААН-д үнэлгээ, хяналт шалгалт хийнэ. Үнэлгээ, хяналт шалгалт хийх баг нь 2 ба түүнээс дээш бүрэлдэхүүнтэй байна.

Импортын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч гадаадын ААН болон тухайн улсын эрх бүхий байгууллага нь үнэлгээ, хяналт шалгалт гүйцэтгэхэд туслалцаа үзүүлнэ.

**14 дүгээр зүйл.** ГЕГ үнэлгээний дүнд үндэслэн шаардлага хангасан импортын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч гадаадын ААН-ийг бүртгэн бүртгэлийн дугаар олгож тухайн улсын эрх бүхий байгууллага эсвэл ААН-д бичгээр мэдэгдэнэ. Шаардлага хангаагүй ААН-ийг бүртгэхээс татгалзаж тухайн улсын эрх бүхий байгууллага эсвэл ААН-д бичгээр мэдэгдэнэ.

**15 дугаар зүйл.** Бүртгэлтэй ААН нь БНХАУ-руу хүнсний бүтээгдэхүүн экспортлохдоо хүнсний бүтээгдэхүүний дотор, гадна савлагаан дээр хятадын бүртгэлийн дугаар эсвэл тухайн улсын эрх бүхий байгууллагын зөвшөөрлийн дугаарыг тэмдэглэнэ.

**16 дугаар зүйл.** Импортын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч гадаадын ААН-ийн бүртгэлийн хүчинтэй хугацаа 5 жил байна.

ГЕГ нь импортын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч гадаадын ААН-ийг бүртгэхдээ бүртгэлийн хүчинтэй байх хугацааны эхлэх, дуусах өдрийг тодорхойлно.

**17 дугаар зүйл.** ГЕГ нь бүртгэсэн импортын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч гадаадын ААН-ийн нэрсийг нийтэд мэдээлнэ.

### **БҮЛЭГ 3. БҮРТГЭЛИЙН ДАРААХ ЗОХИЦУУЛАЛТ**

**18 дугаар зүйл.** ГЕГ өөрөө буюу өөрийн итгэмжит байгууллагаар дамжуулан үнэлгээний баг бүрдүүлэн импортын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч гадаадын ААН бүртгэлийн шаардлагыг үргэлжлүүлэн хангаж буй эсэхэд давтан үнэлгээ хийнэ. Үнэлгээний баг 2 ба түүнээс дээш бүрэлдэхүүнтэй байна.

**19 дүгээр зүйл.** Бүртгэлийн хүчинтэй хугацаанд импортын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч гадаадын ААН-ийн мэдээлэлд ямар нэгэн өөрчлөлт орсон тохиолдолд тухайн өөрчлөлтийг бүртгүүлэх хүсэлт гаргахдаа дараах материалыг бүрдүүлж ГЕГ-т илгээнэ:

- 1) Орсон өөрчлөлтийг өмнөх мэдээлэлтэй харьцуулсан хүснэгт,
- 2) Орсон өөрчлөлтийг нотлох бичиг баримтууд,

ГЕГ үнэлгээ хийж боломжтой гэж үзвэл бүртгэлийн мэдээлэлд өөрчлөлт оруулна.

Үйлдвэрийн байршил, хууль ёсны төлөөлөгч, тухайн улсын эрх бүхий байгууллагын бүртгэлийн дугаар өөрчлөгдсөн тохиолдолд дахин шинээр бүртгүүлэх хүсэлт гаргана. Энэ тохиолдолд ГЕГ-аас олгосон бүртгэлийн дугаар шууд хүчингүй болно.

**20 дугаар зүйл.** Импортын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч гадаадын ААН бүртгэлээ сунгуулах шаардлагатай бол хүчинтэй хугацаа дуусахаас 3-6 сарын өмнө энэ бүртгэлийн журмын дагуу ГЕГ-т бүртгэлээ сунгуулах тухай хүсэлт гаргахдаа дараах материалыг бүрдүүлж илгээнэ:

- 1) Бүртгэлээ сунгуулах тухай хүсэлт,
- 2) Бүртгэл сунгасны дараа үргэлжлүүлэн бүртгэлийн шаардлагыг хангаж ажиллах тухай мэдэгдэл,

ГЕГ бүртгэл сунгах шаардлага хангасан ААН-ийн бүртгэлийн хугацааг сунгах ба бүртгэлийн хугацааг дахин 5 жилээр сунгана.

**21 дүгээр зүйл.** Бүртгэлтэй ААН-ийг дараах тохиолдолд ГЕГ-аас бүртгэлийг хүчингүй болгож, тухайн улсын эрх бүхий байгууллага, эсвэл импортын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч гадаадын ААН-д албан ёсоор мэдэгдэн, нийтэд мэдээлнэ.

- 1) Хүсэлт гаргах зааврын дагуу бүртгэлийн хугацааг сунгуулаагүй,
- 2) Бүртгэлтэй ААН өөрөө эсвэл тухайн улсын эрх бүхий байгууллагаас импортын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч гадаадын ААН-ийн бүртгэлийг хүчингүй болгох хүсэлт гаргасан,
- 3) Энэ журмын 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан шаардлагыг хангаагүй бол.

**22 дугаар зүйл.** Импортын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч бүртгэлтэй гадаадын ААН-д оршин буй тухайн улсын эрх бүхий байгууллага бүртгэлийн нөхцөл, шаардлагыг үргэлжлүүлэн хангаж байгаа эсэхэд байнгын хяналт тавьж, шаардлага хангаагүй тохиолдолд зөрчил, дутагдлыг арилгуулж, бүртгэлийн шаардлага хангах хүртэл БНХАУ руу хүнсний бүтээгдэхүүн экспортлохыг түр зогсооно.

Импортын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч гадаадын ААН нь бүртгэлийн шаардлагыг хангаагүйг өөрөө илрүүлсэн тохиолдолд зөрчил, дутагдлыг арилгаж, бүртгэлийн шаардлага хангах хүртэл БНХАУ руу бүтээгдэхүүнээ экспортлохыг түр зогсооно.

**23 дугаар зүйл.** ГЕГ-аас импортын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч бүртгэлтэй гадаадын ААН бүртгэлийн шаардлагын зөрчлийг илрүүлсэн тохиолдолд журамд заасан хугацаанд зөрчил, дутагдлыг залруулах арга хэмжээ авах ба энэ хугацаанд ААН-ийн бүтээгдэхүүний импортыг түр зогсооно.

Тухайн улсын эрх бүхий байгууллагын санал болгосноор БНХАУ-д бүртгүүлсэн ААН-ийн бүтээгдэхүүнийг импортлохыг түр зогсоосон бол тухайн улсын эрх бүхий байгууллага заасан хугацаанд зөрчил, дутагдлыг арилгахад хяналт тавьж, ГЕГ-т зөрчил, дутагдлыг арилгасан тухай тайлан болон бүртгэлийн шаардлагыг хангасан талаарх мэдэгдлийг бичгээр хүргүүлнэ.

Импортын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч бүртгэлтэй гадаадын ААН өөрөө буюу төлөөний байгууллага нь импортын эрхийг түр зогсоосон бол ГЕГ-аас заасан хугацаанд зөрчил, дутагдлыг арилгаж, зөрчил, дутагдлаа арилгаж, бүртгэлийн шаардлага хангасан тухай мэдэгдлээ ГЕГ-т бичгээр хүргүүлнэ.

ГЕГ нь тухайн ААН-ийн зөрчил, дутагдлаа арилгасан байдлыг хянан үзээд, шаардлага хангасны дараа хүнсний бүтээгдэхүүн импортлох эрхийг сэргээнэ.

**24 дүгээр зүйл.** Импортын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч бүртгэлтэй ААН дараах зөрчлийг гаргасан бол ГЕГ бүртгэлээс хасч, нийтэд мэдээлнэ.

- 1) Тухайн ААН-ээс шалтгаалан хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдалтай холбоотой томоохон халдвар, хордлого гарсан тохиолдолд;
- 2) БНХАУ-руу экспортлож байгаа хүнсний бүтээгдэхүүнд хилийн хорио цээрийн хяналт, шалгалт хийх үед хүнсний аюулгүй байдлын ноцтой зөрчил илэрсэн бол;
- 3) Тухайн ААН-ийн хүнсний аюулгүй байдал, ариун цэврийн удирдлагын тогтолцоо нь БНХАУ-д импортлох хүнсний бүтээгдэхүүний эрүүл ахуй, аюулгүй байдлын баталгааг хангахгүй болсон үед;
- 4) Тухайн ААН зөрчил, дутагдлаа арилгах арга хэмжээ авсан боловч бүртгэлийн шаардлагыг хангахгүй хэвээр байгаа тохиолдолд;

- 5) Хуурамч бичиг баримт бүрдүүлсэн эсвэл бодит нөхцөл, байдлыг нуун дарагдуулсан бол;
- 6) БНХАУ-ын ГЕГ-аас давтан хяналт шалгалт хийх болон ослыг мөрдөн шалгахад хамтарч ажиллахаас татгалзсан;
- 7) ААН нь бүртгэлийн дугаарыг түрээслүүлсэн, зээлдүүлсэн, шилжүүлсэн, дамжуулан худалдсан, хууль бусаар ашигласан тохиолдолд.

#### **БҮЛЭГ 4. БУСАД**

**25 дугаар зүйл.** Олон улсын байгууллага, эсвэл БНХАУ руу хүнсний бүтээгдэхүүн экспортлож буй улсын эрх бүхий байгууллага халдварт өвчин дэгдсэн тухай мэдээлсэн, түүнчлэн импортын хүнсний бүтээгдэхүүнд хилийн хорио цээрийн хяналт шалгалт хийх үед халдварт өвчний шинж тэмдэг илэрсэн, мөн нийтийг хамарсан эрүүл мэндийн ноцтой асуудал (халдвар, хордлого) гарсан үед БНХАУ-ын ГЕГ-аас тухайн улсад энэ төрлийн хүнсний бүтээгдэхүүний импортоо түр зогсоохыг мэдэгдэж, энэ хугацаанд тухайн улсаас хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг ААН-ийн бүртгэлийн хүсэлтийг хүлээж авахгүй.

**26 дугаар зүйл.** Тухайн улсын “эрх бүхий байгууллага гэдэг”-т хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч ААН-д хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуй, ариун цэврийн хяналт тавих эрх бүхий байгууллагыг ойлгоно.

**27 дугаар зүйл.** Энэ журмын тайлбарыг ГЕГ хариуцна.

**28 дугаар зүйл.** Энэ журмыг 2022 оны 1 сарын 1-нээс эхлэн хэрэгжүүлнэ. 2012 оны 3 сарын 22-ний өдрийн БНХАУ-ын Хорио цээр, Чанарын хяналт, шалгалтын ерөнхий газрын 145-р тушаал, 2018 оны 11 сарын 23-ны өдрийн ГЕГ-ын 243-р тушаал, “Импортын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч гадаадын ААН-ийг бүртгэх журам” энэ өдрөөс эхлэн хүчингүй болно.

**БНХАУ-ЫН ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР /ГЕГ/-ЫН  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗААВАР  
(000129012000)**

**“Импортын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч гадаадын аж ахуйн нэгжийг  
бүртгэх журам”-ыг хэрэгжүүлэх ГЕГ-ын заавар**

1. **НЭР:** “Импортын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч гадаадын аж ахуйн нэгжийг бүртгэх журам”
2. **ТӨРӨЛ АНГИЛАЛ:** Захиргааны зөвшөөрөл
3. **ҮНДЭСЛЭЛ:**
  - 1) БНХАУ-ын Хүнсний аюулгүй байдлын тухай хууль”-ийн 96-р зүйл: “БНХАУ-д хүнсний бүтээгдэхүүн импортлогч гадаад улсад бизнес эрхлэгчид буюу тэдний төлөөлөгчид нь импортлох хүнсний бүтээгдэхүүнийг хилийн хорио цээр, хяналт шалгалтын газар бүртгүүлнэ. БНХАУ-д импортын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч гадаадын аж ахуйн нэгж /ААН/ нь хилийн хорио цээр, хяналт шалгалтын газар бүртгүүлнэ. Бүртгүүлсэн ААН хуурамч бичиг баримт бүрдүүлсэн буюу тухайн ААН-ээс шалтгаалсан импортын хүнсний бүтээгдэхүүний хүнсний аюулгүй байдалтай холбоотой онц ноцтой асуудал гаргасан бол тухайн ААН-ийн бүртгэлийг БНХАУ-ын хилийн хорио цээр, хяналт шалгалтын газар хүчингүй болгож, нийтэд мэдээнэ. БНХАУ-ын хилийн хорио цээр, хяналт шалгалтын газар бүртгэлтэй хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч ААН, импортлогч, экспортлогч, тэдний төлөөлөгчийн нэрсийг тогтмол хугацаатай мэдээлж байна.”
  - 2) “БНХАУ-ын Хүнсний Аюулгүй байдлын тухай хуулийг хэрэгжүүлэх тухай журам”-ын 50 дугаар заалт:” Хилийн хорио цээрийн хяналт шалгалтын байгууллага /ХХЦХШБ/ нь хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч гадаадын бүртгэлтэй ААН шаардлага хангаагүй тохиолдолд зөрчлийг арилгах хугацаа өгөх ба энэхүү хугацаанд бүтээгдэхүүн импортлохыг түр зогсооно, зөрчлийг арилгасан ч бүртгэлийн шаардлага хангаагүй бол бүртгэлийг ХХЦХШБ хүчингүй болгон нийтэд мэдээнэ.”
  - 3) “БНХАУ-д импортын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч гадаадын ААН-ийн бүртгэх захиргааны журам” (Гаалийн Ерөнхий Газрын 248 дугаар тогтоолоор баталсан).  
*/Энэ журмын орчуулгыг тусад нь бэлтгэсэн болно./*
4. **ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА:** ГЕГ-ын Импорт, Экспортын Хүнсний Аюулгүй Байдлын Газар
5. **ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА:** байнгын
6. **ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА:** байнгын
7. **ҮР ДҮН:** ГЕГ-ын албан ёсны цахим хуудсаар импортын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч гадаадын ААН-ийн жагсаалтыг нийтэд мэдээлэх



**8. ҮР ДҮНГИЙН ХЭЛБЭР:** тодорхойгүй

**9. ТӨЛБӨР ХУРААМЖ:** байхгүй

**10. ТӨЛБӨРИЙН БАРИМТ:** байхгүй

**11. ХҮСЭЛТ ГАРГАХ НӨХЦӨЛ:**

- 1) Тухайн улсын хүнсний аюулгүй байдлын тогтолцоо нь ГЕГ-ын хяналт, үнэлгээний шаардлагыг хангасан байна.
- 2) Тухайн улсын төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр болон үр дүнтэй хяналтын дор үйл ажиллагаа явуулдаг байна.
- 3) Импортын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч гадаадын ААН нь хүнсний аюулгүй байдал, ариун цэврийн үр дүнтэй удирдлагын тогтолцоог нэвтрүүлсэн, хууль ёсны дагуу хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг, экспортлодог, түүнчлэн БНХАУ-д экспортлож буй хүнсний бүтээгдэхүүн нь БНХАУ-ын хүнсний аюулгүй байдлын стандарт, холбогдох хууль дүрмийн шаардлагыг хангасан байна.
- 4) ГЕГ болон тухайн улсын эрх бүхий байгууллага хооронд байгуулсан хэлэлцээр, хорио цээр, хяналт шалгалтын шаардлагыг хангасан байна.

**12. ААН ХҮСЭЛТ ГАРГАХАД БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ**

*1) Тухайн улсын эрх бүхий байгууллагаас бүртгүүлэхээр санал болгосон 18 нэрийн импортын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч гадаадын ААН-ийг бүртгэхэд бүрдүүлэх материал*

**1. Анх удаа бүртгүүлэх хүсэлт гаргаж буй ААН-ийн бүрдүүлэх материал**

№	Бүрдүүлэх материалын нэр	ш	Илгээх хэлбэр	Хэл
1	Тухайн улсын эрх бүхий байгууллагын албан бичиг	1	Цаас, цахимаар	Хятад, Англи
2	Тухайн улсын эрх бүхий байгууллагаас бүртгүүлэхээр санал болгож буй ААН -ийн нэрс /хавсралт 1/	1	Цаас, цахимаар	Хятад Англи
3	Бүртгүүлэхээр санал болгож буй ААН-ийн бүртгүүлэх хүсэлт /хавсралт 2/	1	Цаас, цахимаар	Хятад Англи
4	ААН-г тодорхойлох эрх зүйн бичиг баримтууд. Үүнд тухайн улсын эрх бүхий байгууллагаас олгосон бүртгэлийн гэрчилгээ болон зөвшөөрөл,	1	Цаас, цахимаар	Хятад Англи
5	Тухайн улсын эрх бүхий байгууллагын санал болгосон ААН нь бүртгэлийн нөхцөл, шаардлагыг хангасан тухай мэдэгдэл /хавсралт 3/	1	Цаас, цахимаар	Хятад Англи



6	Тухайн улсын эрх бүхий байгууллагын ААН-д хийсэн хяналт, шалгалтын тайлан буюу тухайн ААН-ийн бүртгүүлсэн нөхцөл, хяналт, шалгалтын шаардлага хангасан үзүүлэлтүүд /хавсралт 4/	1	Цаас, цахимаар	Хятад Англи
---	---	---	----------------	----------------

## 2. ААН-ийн бүртгэлд өөрчлөлт орсон үед бүрдүүлэх материал

№	Бүрдүүлэх материалын нэр	ш	Илгээх хэлбэр	хэл
1	Тухайн улсын эрх бүхий байгууллагын өөрчлөлт хийх тухай хүсэлт	1	Цаас, цахимаар	Хятад Англи
2	ААН-ийн бүртгэлд орсон өөрчлөлтийг өмнөх мэдээлэлтэй харьцуулсан хүснэгт /хавсралт 5/	1	Цаас, цахимаар	Хятад Англи
3	Орсон өөрчлөлтийг нотлох бичиг баримтууд	1	Цаас, цахимаар	Хятад Англи

## 3. ААН-ийн бүртгэлийн хугацаа сунгахад бүрдүүлэх материал

№	Бүрдүүлэх материалын нэр	ш	Илгээх хэлбэр	хэл
1	Тухайн улсын эрх бүхий байгууллагаас бүртгэлийн хугацаа сунгах тухай хүсэлт	1	Цаас, цахимаар	Хятад Англи
2	Бүртгэлийн хугацаа сунгахаар мэдүүлж байгаа ААН –ийн нэрс /хавсралт 6/	1	Цаас, цахимаар	Хятад Англи
3	ААН-ийн бүртгэлийн хугацаа сунгах хүсэлт /хавсралт 7/	1	Цаас, цахимаар	Хятад Англи
4	ААН-ийн бүртгэлийн хугацаа сунгах шаардлагыг хангасан тухай мэдэгдэл /хавсралт 8/	1	Цаас, цахимаар	Хятад Англи

## 4. ААН-ийн бүртгэлийг хүчингүй болгоход бүрдүүлэх материал

№	Бүрдүүлэх материалын нэр	ш	Илгээх хэлбэр	хэл
1	Тухайн улсын эрх бүхий байгууллагаас гаргасан ААН-ийн бүртгэлийг “хүчингүй болгох” тухай хүсэлт	1	Цаас, цахимаар	Хятад Англи
2	Бүртгэлийг хүчингүй болгох ААН-ийн нэрс /хавсралт 9/	1	Цаас, цахимаар	Хятад Англи
3	Бүртгэлтэй ААН-ийн бүртгэлийг хүчингүй болгох тухай хүсэлт /хавсралт 10/	1	Цаас, цахимаар	Хятад Англи

2) 18 нэр төрлийн бүтээгдэхүүнээс бусад төрлийн импортын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч гадаадын ААН-ийг бүртгэхэд бүрдүүлэх материал

### 1. ААН анх удаа бүртгүүлэхэд бүрдүүлэх материал

№	Бүрдүүлэх материалын нэр	ш	Илгээх хэлбэр	хэл
1	ААН өөрөө бүртгүүлэх хүсэлт гаргах /хавсралт 11/	1	Цаас, цахимаар	Хятад Англи
2	ААН-д оршин буй улсын эрх бүхий байгууллагаас олгосон гэрчилгээнүүд	1	Цаас, цахимаар	Хятад Англи
3	ААН нь бүртгэлийн нөхцөл шаардлагыг хангасан тухай өөрийн тодорхойлолт /хавсралт 12/	1	Цаас, цахимаар	Хятад Англи

## 2. ААН-д өөрчлөлт орсон үед бүрдүүлэх материал

№	Бүрдүүлэх материалын нэр	ш	Илгээх хэлбэр	хэл
1	ААН-д орсон өөрчлөлтийг өмнөх мэдээлэлтэй харьцуулсан хүснэгт /хавсралт 5/	1	Цаас, цахимаар	Хятад Англи
2	Орсон өөрчлөлтийг нотлох бичиг баримтууд	1	Цаас, цахимаар	Хятад Англи

## 3. ААН-ийн бүртгэлийн хугацааг сунгуулахад бүрдүүлэх материал

№	Бүрдүүлэх материалын нэр	ш	Илгээх хэлбэр	хэл
1	ААН-ийн бүртгэлийн хугацааг сунгуулах өөрийн хүсэлт /хавсралт 13/	1	Цаас, цахимаар	Хятад англи
2	ААН-ийн бүртгэлийн хугацааг сунгуулах шаардлага хангасан тухай өөрийн тодорхойлолт /хавсралт 14/	1	Цаас, цахимаар	Хятад англи

## 4. ААН-ийн бүртгэлийг хүчингүй болгоход бүрдүүлэх материал

№	Бүрдүүлэх материалын нэр	ш	Илгээх хэлбэр	хэл
1	ААН нь бүртгэлийг хүчингүй болгох тухай хүсэлт гаргана /хавсралт 10/	1	Цаас, цахимаар	Хятад англи

## 13. МАТЕРИАЛ БҮРДҮҮЛЭХ, БҮРТГЭХ ДАРААЛАЛ

1) *Импортын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч гадаадын ААН-ийн бүртгүүлэх хүсэлт хүлээн авах, үнэлгээ, шинжилгээ хийх, шийдвэр гаргах*

### 1. Хүсэлт

Импортын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч гадаадын ААН-ийг бүртгэх, бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлийн хугацааг сунгах, бүртгэлийг хүчингүй болгохдоо тухайн улсын эрх бүхий байгууллагын хүсэлт, ААН-ийн өөрийн хүсэлт хоёрыг үндэслэнэ.

Дараах 18 нэр, төрлийн импортын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч гадаадын ААН-ийг тухайн улсын эрх бүхий байгууллагаас ГЕГ-т бүртгүүлэхээр санал болгоно.

- 1) мах, махан бүтээгдэхүүн,
- 2) өлөн гэдэс,
- 3) далайн гаралтай хүнсний бүтээгдэхүүн,
- 4) сүү, сүүн бүтээгдэхүүн,
- 5) хараацайн үүр болон үүрээр хийсэн бүтээгдэхүүн,
- 6) зөгийн гаралтай бүтээгдэхүүн,
- 7) өндөг болон өндгөөр хийсэн бүтээгдэхүүн,
- 8) хүнсний өөх, тос болон тосны түүхий эд,
- 9) шанзтай гурилан бүтээгдэхүүн,
- 10) хүнсний үр тариа,
- 11) нунтагласан үр тарианы бүтээгдэхүүн, соёолж (malt)
- 12) шинэ болон хатаасан ногоо, шошнууд
- 13) амтлагчууд,
- 14) самар болон самрын үр,
- 15) хатаасан жимс,
- 16) хуураагүй кофены үр болон какаогийн шош,
- 17) тусгай зориулалтын хүнс,
- 18) эрүүл мэндийг дэмжих бүтээгдэхүүн.

зэрэг хүнсний бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч гадаадын ААН нь өөрийн оршин буй улсын эрх бүхий байгууллагаас хяналт, шалгалт хийн стандарт шаардлага хангасныг баталгаажуулсны дараа БНХАУ-ын ГЕГ-т бүртгүүлэх саналыг холбогдох материалын хамт илгээнэ.

Дээрх 18 нэрийн импортын хүнсний бүтээгдэхүүнээс бусад хүнсний бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч гадаадын ААН нь өөрөө буюу өөрийн итгэмжит төлөөний хүнээр дамжуулан БНХАУ-ын ГЕГ-т бүртгүүлэх саналыг холбогдох материалын хамт шууд илгээнэ.

## **2. ААН материал бүрдүүлж өгөх**

Тухайн ААН байгаа улс орны эрх бүхий байгууллага нь хүсэлт гаргах, материал бүрдүүлэх талаар БНХАУ-ын ГЕГ-тай хэлэлцэж тохирсноос бусад импортын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч гадаадын ААН-ийг бүртгүүлэх, бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлийн хугацаа сунгах, бүртгэлийг хүчингүй болгох хүсэлтийг “импортын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч гадаадын ААН-ийг бүртгэх журам”-ын дагуу материал бүрдүүлж, БНХАУ-ын ГЕГ-ын бүртгэлийн системд бүртгүүлнэ.

## **3. ААН-ийн бүртгүүлэх материалыг хүлээн авах**

ГЕГ-ын Импорт, Экспортын Хүнсний Аюулгүй Байдлын Газар нь импортын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч гадаадын ААН-ийн бүртгүүлэх хүсэлтийг хүлээж авсны дараа дараах нөхцлийг үндэслэн шийдвэр гаргана:

- 1) Бүрдүүлсэн материал бүртгэлийн шаардлага хангасан бол хүлээн авна,

- 2) Шаардлага хангаагүй, бүрэн бус материалыг хүлээж авснаас хойш ажлын 20 хоногийн дотор ААН байгаа улсын эрх бүхий байгууллага буюу ААН-д нөхөж өгөх шаардлагатай материалыг нэг удаа мэдэгдэнэ,
- 3) “БНХАУ-ын импортын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч гадаадын ААН-ийг бүртгэх заавар”-т хамааралгүй ААН-ийн материалыг хүлээж авахгүй бөгөөд тухайн улсын эрх бүхий байгууллага буюу ААН-д мэдэгдэнэ,
- 4) ААН нь бүртгүүлэх хүсэлт гаргахдаа хуурамч материал бүрдүүлсэн бол хүлээж авахгүй бөгөөд тухайн улсын эрх бүхий байгууллага буюу ААН-д мэдэгдэнэ, бүртгэлтэй ААН хуурамч материал бүрдүүлсэн байвал ГЕГ-ын 248 дугаар тушаалаар баталсан “БНХАУ-ын импортын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч гадаадын ААН-ийг бүртгэх журам”-ын 24 дүгээр зүйлийн дагуу шийдвэрлэнэ. ГЕГ-ын Импорт, Экспортын Хүнсний Аюулгүй Байдлын Газар нь бичгээр, факсаар, имейлээр, өөр бусад харилцаа мэдээллийн хэлбэрээр тухайн улс орны эрх бүхий байгууллага буюу импортын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч гадаадын ААН-д материалыг хүлээн авч шийдвэрлэсэн тухай мэдэгдэнэ.

#### 4. ААН-ийн үнэлгээ, хяналт, шалгалт

Эрсдлийн үнэлгээ болон бодит үнэлгээг үндэслэн ГЕГ-ын Импорт, Экспортын Хүнсний Аюулгүй Байдлын Газар үнэлгээний баг бүрдүүлэн бичиг баримтын шалгалт, цахимаар шалгах, үйлдвэр дээр нь очиж үнэлгээ шалгалт хийх зэргээр бүртгүүлэх хүсэлт гаргасан ААН-ийн бодит нөхцөл байдалд үнэлгээ, шалгалт хийнэ. ААН-ийн үнэлгээ, шалгалт дараах хэлбэрээр явагдана:

1. **ААН-ийн бичиг баримтын шалгалт:** ГЕГ нь үнэлгээний баг бүрдүүлэн тухайн улсын эрх бүхий байгууллага ба ААН-ийн бүрдүүлсэн бичиг баримтыг шалган дутуу нөхөж гүйцээх бичиг баримт мэдээллийг шаардаж болно.
2. **ААН-ийн цахим шалгалт:** ГЕГ нь үнэлгээний баг бүрдүүлэн цахимаар тухайн ААН-ийн хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуй, ариун цэврийн тогтолцооны байдлыг шалгана. Цахим шалгалтад хамрагдаж буй ААН болон тухайн улсын эрх бүхий байгууллага хяналт, шалгалтыг гүйцэтгэхэд туслалцаа үзүүлнэ. Цахим шалгалтаар илэрсэн зөрлийг арилгах саналыг ААН болон тухайн улсын эрх бүхий байгууллагад ГЕГ-аас тавина. Илэрсэн зөрчлийг арилгасан талаар ГЕГ-т тайлангаар эргэж мэдэгдэнэ.
3. **ААН-ийн үйлдвэрт очиж газар дээрх шалгалт хийх:** ГЕГ нь үнэлгээний баг бүрдүүлэн хүсэлт тавьсан ААН-д очин хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуй, ариун цэврийн тогтолцооны хэрэгжилтийг үзэж шалган баталгаажуулна. Газар дээр нь үйлдвэрт шалгалт хийж байх үед ААН болон тухайн улсын эрх бүхий байгууллага шаардлагатай туслалцааг үзүүлнэ.

Газар дээр нь шалгалт хийх явцад илэрсэн зөрчлийг арилгах саналыг БНХАУ-ын ГЕГ тухайн ААН болон тухайн улсын эрх бүхий байгууллагад тавих ба ААН, тухайн улсын төрийн эрх бүхий байгууллага илэрсэн зөрчлийг “засаж арилгасан” тухайгаа эргэж мэдэгдэх, тайлагнах үүрэгтэй.

Үнэлгээний шаардлагууд нь ДХБ, ДМАЭМБ, Хүнсний хууль эрх зүйн хороо, Олон Улсын Ургамал хамгааллын хэлэлцээрт суурилсан байхаас гадна БНХАУ-ын ГЕГ тухайн улсын эрх бүхий байгууллагатай байгуулсан хорио цээрийн шаардлага, БНХАУ-ын холбогдох хууль дүрэм, хүнсний аюулгүй байдлын стандартад нийцсэн байна.

ГЕГ-ын Импорт, Экспортын Хүнсний Аюулгүй Байдлын Газар нь үнэлгээний баг бүрдүүлэн, цахимаар болон үйлдвэрт очиж олон улсын шаардлагын дагуу эрсдлийн үнэлгээ хийх талаар тухайн улс болон ААН-тэй урьдчилан ярилцаж тохирно.

## **5. Тайланд хяналт, шалгалт хийх**

ГЕГ-ын Импорт, Экспортын Хүнсний Аюулгүй Байдлын Газар нь үнэлгээний багийн ажлын тайланд хяналт, шалгалт хийнэ.

## **6. Бүртгэж дугаар олгох**

ГЕГ нь хяналт шалгалт, үнэлгээний дүнг үндэслэн шаардлага хангасан ААН-ийг бүртгэн БНХАУ-ын бүртгэлийн дугаар олгоно. БНХАУ-ын бүртгэлийн дугаар олгосон тухай тухайн улсын эрх бүхий байгууллага буюу импортын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч гадаадын ААН-д мэдэгдэнэ; шаардлага хангаагүй ААН-ийг бүртгэхгүй ба энэ талаар тухайн улсын эрх бүхий байгууллага буюу импортын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч гадаадын ААН-д мэдэгдэнэ.

БНХАУ-ын ГЕГ-ын Импорт, Экспортын Хүнсний Аюулгүй Байдлын Газар нь бичгээр, факсаар, имейлээр, өөр бусад харилцаа мэдээллийн хэлбэрээр тухайн улс орны эрх бүхий байгууллага буюу ААН-д бүртгэлийн талаар мэдэгдэнэ.

### **2) Бүртгэлд өөрчлөлт оруулах**

Бүртгэсэн ААН-ийн бүртгэлд өөрчлөлт орох үед тухайн улс орны эрх бүхий байгууллага буюу ААН нь хүсэлт гаргах зааврын 12 дугаар зүйлд дурдсаны дагуу өөрчлөлт хийхэд шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлнэ.

Өөрчлөлт нь ААН-ийн хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал, эрүүл ахуй, ариун цэвэрт нөлөөлөхөөргүй /тухайлбал, аж ахуйн нэгжийн нэр өөрчлөгдөх гэх мэт/ байвал ГЕГ бүртгэлийн мэдээлэлд өөрчлөлт оруулна.

Хяналт үнэлгээ хийх үед өөрчлөлт нь тухайн ААН-ийн үйлдвэрлэж буй хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал, эрүүл ахуй, ариун цэвэрт нөлөөлөх тохиолдолд өөрчлөлтийг зөвшөөрөхгүй ба тухайн улс орны эрх бүхий байгууллага буюу ААН нь хүсэлт гаргах зааврын дагуу шинээр бүртгүүлэх хүсэлт гаргана. ААН-ийн шинээр бүртгүүлэх хүсэлтийг зөвшөөрсний дараа өмнөх бүртгэлийн дугаар хүчингүй болж БНХАУ-ын бүртгэлээс хасагдана.

ААН-ийн үйлдвэрийн байршил өөрчлөгдсөн, хууль ёсны төлөөлөгч өөрчлөгдсөн, тухайн улсын эрх бүхий байгууллагын олгосон бүртгэлийн дугаар өөрчлөгдсөн тохиолдолд ААН дахин шинээр бүртгүүлэх хүсэлт гаргана. ААН-ийн шинээр бүртгүүлэх хүсэлтийг

зөвшөөрсний дараа өмнө нь БНХАУ-д бүртгэсэн дугаар хүчингүй болж, бүртгэлээс хасагдана.

ААН-ийн үйлдвэрийн байршлын өөрчлөлт гэдэг нь БНХАУ-руу импортын хүнс үйлдвэрлэж буй үйлдвэр нүүснийг хэлнэ. Харин үйлдвэрийн захиргаа нүүсэн тохиолдолд үйлдвэрийн байршил өөрчлөгдсөнд тооцохгүй.

Хуулийн этгээдийн өөрчлөлт гэдэг нь импортын хүнс үйлдвэрлэгч гадаадын ААН-ийн өмчлөгч өөрчлөгдөхийг хэлнэ. Хэрэв жинхэнэ өмчлөгч өөрчлөгдөөгүй харин жинхэнэ өмчлөгчийг төлөөлж буй ААН-ийн гүйцэтгэх шатны менежерүүдэд өөрчлөлт орсон бол тухайн ААН өөрчлөлт орсон тухай хүсэлтийг БНХАУ-ын ГЕГ-т гаргаж, БНХАУ-ын ГЕГ-аас тухайн өөрчлөлтөд үнэлгээ хийн тухайн өөрчлөлт нь ААН-ийн үйлдвэрлэж буй хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал, эрүүл ахуй, ариун цэвэрт бодитой нөлөөлсөн эсэхийг үндэслэн шийдвэр гаргана.

### **3) Бүртгэлийн хугацааг сунгах.**

Бүртгэлтэй ААН нь бүртгэлийн хугацаа дуусахаас 3-6 сарын өмнө тухайн улсын эрх бүхий байгууллага буюу ААН нь энэ зааврын 12 дугаар зүйлд” заасан бүртгэлийн хугацаа сунгахад шаардлагатай материалыг бүрдүүлж өгнө.

Бүртгэлийн хугацаа сунгахад ААН-ийн бүрдүүлсэн материалууд шаардлага хангасан байвал бүртгэлийн дугаарын хугацааг сунгана. Харин шаардлагад нийцэхгүй байвал бүртгэлийн дугаарын хугацааг сунгахгүй бөгөөд бичгээр тухайн улсын эрх бүхий байгууллага буюу ААН-д мэдэгдэнэ. Бүртгэлийн хугацаа дуусахад бүртгэлийн дугаар шууд хүчингүй болж, бүртгэлээс хасагдана.

БНХАУ-ын ГЕГ-ын Импорт, Экспортын Хүнсний Аюулгүй Байдлын Газар нь бичгээр, факсаар, имейлээр, өөр бусад харилцаа мэдээллийн хэлбэрээр тухайн улс орны эрх бүхий байгууллага буюу ААН-д бүртгэлийн талаар мэдэгдэнэ.

### **4) ААН-ийн бүртгэлийн дугаарыг хүчингүй болгох.**

Бүртгэлтэй ААН нь бүртгэлийн эрхээ хасуулах хүсэлт гаргах үед тухайн улсын эрх бүхий байгууллага буюу ААН нь энэ зааврын 12 дугаар зүйлд заасан бүртгэлийн дугаар хасуулах материалыг бүрдүүлнэ.

БНХАУ-ын ГЕГ-ын Импорт, Экспортын Хүнсний Аюулгүй Байдлын газар нь бүрдүүлсэн материал шаардлага хангасан байвал бүртгэлээс хасч тухайн улсын эрх бүхий байгууллага буюу ААН-д мэдэгдэн улмаар нийтэд мэдээлнэ.

## **14. БҮРТГЭЛИЙН ХЭЛБЭР.**

Тухайн улсын эрх бүхий байгууллага БНХАУ-ын ГЕГ-т ААН-ийг бүртгүүлэх хүсэлт гаргах талаар хийсэн хэлэлцээрээс бусад тохиолдолд ААН-ийг бүртгэх, бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлийн хугацаа сунгах, бүртгэлийг хүчингүй болгох хүсэлт нь “импортын

хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч гадаадын ААН-ийг бүртгэх заавар”-ын дагуу бүртгэлийн системд хийгдэнэ.

**15. БНХАУ-ЫН ГЕГ–Т ОЧИХ ТОО:** байхгүй

**16. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ШАЛГУУР:**

Хүсэлт гаргахдаа бүрдүүлсэн материал нь үнэн зөв, бүрэн бүтэн, оновчтой, хүчинтэй байна. Хүсэлт гаргахдаа бүрдүүлсэн материал нь БНХАУ-ын ГЕГ болон тухайн улсын эрх бүхий байгууллагын хооронд тохирсон хорио цээр, хяналт шалгалтын шаардлагыг хангасан, БНХАУ-ын холбогдох дүрэм журам болон хүнсний аюулгүй байдлын стандарт шаардлагыг хангасан байна.

**17. ХАМРАХ ХҮРЭЭ:** үгүй

**18. УРЬДЧИЛСАН ЗАХИАЛГА:** үгүй

**19. ЦАХИМААР ТӨЛБӨР ХИЙХ:** үгүй

**20. БУУХИА ШУУДАН ИЛГЭЭМЖ:** үгүй

**21. МАТЕРИАЛ/ БИЧИГ БАРИМТ ХҮЛЭЭН АВАХ ГАЗАР:**

1) БНХАУ-ын ГЕГ, Бээжин Жан Го Мин хаалга, дотор өргөн чөлөө, 6 тоот, БНХАУ-ын ГЕГ-ын Импорт, Экспортын Хүнсний Аюулгүй Байдлын Газар, шуудангийн дугаар 100005

2) Цахимаар хүлээж авах: <https://cifer.singlewindow.cn>, БНХАУ-ын олон улсын худалдааны нэг цэгийн үйлчилгээний цонх ([www.singlewindow.cn](http://www.singlewindow.cn)) энэ сайтаар үйлчлүүлж болно.

**22. АЖЛЫН ЦАГ:**

**1) ААН -ийн хүсэлт гаргах цаг:**

**Цахимаар хүлээж авах цаг:** 24 цаг

**Дипломат шугам:** ажлын өдрийн 8:00-17:00

**2) ГЕГ-ын ажлын цаг:** ажлын өдрийн 8:00-17:00

**23. ЛАВЛАХ УТАС:** 12360 гаалийн үйлчилгээний утас

**24. ХЯНАЛТЫН УТАС:** 12360 гаалийн утас